



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2023 оны 03 сарын 30 өдөр

Дугаар 04

Чойр

“Нээлттэй-Говьсүмбэр” хөтөлбөрийг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.8, 35.1.17, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2, 52 дугаар зүйлийн 52.1.2, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, 46 дугаар зүйлийн 46.1 дэх заалтууд, Монгол Улсын урт хугацааны бодлого “Алсын хараа-2050”, Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн “Хот хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах арга хэмжээний тухай” 419 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


1. Говьсүмбэр аймагт шилжин ирж буй иргэд, аж ахуй нэгж, байгууллагыг дэмжих зорилгоор хэрэгжүүлэх “Нээлттэй-Говьсүмбэр” хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. “Нээлттэй-Говьсүмбэр” хөтөлбөрийн хэрэгжилтийг хууль, тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг төсөвт тусгаж, жилийн эцэст тайлагнахыг аймгийн Засаг дарга (Г.Батсуурь)-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нарийн бичгийн дарга (Ж.Оюунбилэг)-т даалгасугай.

ДАРГА

Ш.БИЛЭГГҮМБЭРЭЛ



Говьсүмбэр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2023 оны 03 дугаар сарын 30 ны өдрийн ээлжит бус  
15-р хуралдааны 04 дугаар тогтоолын хавсралт



## “НЭЭЛТТЭЙ-ГОВЬСҮМБЭР” ХӨТӨЛБӨР

### Нэг. Нийтлэг үндэслэл

**Хууль, эрх зүйн үндэслэл:** Монгол Елсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.3, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийг тус тус үндэслэн энэхүү хөтөлбөрийг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулна.

Мөн Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 157 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн 2022-2024 онд хэрэгжүүлэх ажлын ерөнхий төлөвлөгөөгөөр салбарын яам, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжүүдийн авч хэрэгжүүлэх ажлын чиглэлүүдийг баталсан бөгөөд Монгол улсын урт хугацааны бодлого “Алсын хараа-2050”, УИХ-ын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”, Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн “Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах арга хэмжээний тухай” 419 дүгээр тогтоол, Засгийн газрын 2022 оны хуралдааны 56 дугаар тэмдэглэлийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Улаанбаатар хотоос орон нутагт шилжин ирж буй иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжих зорилгоор “Нээлттэй Говьсүмбэр” хөтөлбөрийг боловсрууллаа.

Шинэ сэргэлтийн бодлого, “Нээлттэй Говьсүмбэр” хөтөлбөрийг хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусган батлуулж, орон нутгийн онцлогт тохирсон байдлаар, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэд, олон нийтийн оролцоотойгоор хэрэгжүүлэх шаардлага бий болж байна.

Иймд орон нутгийн өнөөгийн нөхцөл байдал, онцлог, нөөц боломж, эдийн засаг, нийгмийн хөгжил, аймгийн бодлогын зорилго, зорилттой уялдуулан шилжин ирэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, олон нийтийг дэмжих, мэдээллийг хүргэх



зорилгоор “НЭЭЛТТЭЙ ГОВЬСҮМБЭР ХӨТӨЛБӨР” (цаашид “Хөтөлбөр” гэх)-ийг боловсруулан хэрэгжүүлнэ.

**Ач холбогдол:** Энэхүү хөтөлбөр нь аймаг, орон нутгийн хүм амын тогтвортой өсөлтийг хангаж, эдийн засгийн нөөцийг нэмэгдүүлэх боломж бүрдэх бөгөөд хүний хөгжлийг хангах, нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, шилжин суурьшигчдын ажиллаж, амьдрах орчин нөхцлийг бүрдүүлэх ач холбогдолтой юм.

**Өнөөгийн нөхцөл байдал:**

Манай аймаг нь 18042 хүн амтай бөгөөд нийт хүн амын 8979 хүн буюу 49.8 хувийг эрэгтэйчүүд 9063 хүн буюу 50.2 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Насны бүтцээр ангилан авч үзвэл 0-18 настай иргэн 7405, 19-35 настай иргэн 4650, 36-55 настай иргэн 4228, 56-аас дээш настай иргэн 1870 байна. Нийт хүн амын 80 хувь нь Сүмбэр суманд, 11.8 хувь Шивээговь суманд, 8.2 хувь нь Баянтал суманд тус тус амьдарч байна. Нийт 5265 өрхтэй, өрхийн 37.4 хувь нь уламжлалт сууц гэрт, 60.7 хувь нь байшинд, 1.9 хувь нь бусад төрлийн сууцанд амьдарч байна.

Говьсүмбэр аймаг нь дэд бүтэц зам харилцааны хувьд сайн хөгжсөн. Тус аймгийн нутгаар Москва-Улаанбаатар-Бээжинг холбосон транс Сибирийн олон улсын транзит төмөр зам, ОХУ-БНХАУ-г холбосон авто зам, агаарын замын коридор дайран өнгөрдөг. Цахилгаан эрчим хүчний дамжуулах болон түгээх станцууд байрлаж, Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Хэнтий аймгуудын 19 төв суурин газрууд, томоохон үйлдвэрүүд, айл өрхийн цахилгаан эрчим хүчээр хангадаг.

Мөн томоохон компаниудын шатах, тослох материалын агуулах, хангамжийн баазууд байрлаж, говийн бүсийн аймгуудаас стратегийн тоомоохонд орд газрууд болох Оюутолгой, Таван толгойн ордуудыг бензин шатахуунаар ханган ажилладаг.

Монгол улсын хойд хилээс өмнөд хил хүртэл тавигдсан шилэн кабелийн шугамд холбогдож, дэлхийн аль ч улс оронтой телефон болон интернетээр харилцах боломж бүрдсэн байдаг.

Улсын хэмжээнд томд орох Шивээ-Овоогийн нүүрсний уурхайтай. Жилдээ 2 сая тонн нүүрс олборлодог бөгөөд 300 жилийн нөөцтэй.

Дотоодын нийт бүтээгдэхүүн 2022 онд 155,315.9 сая.төгрөг, нэг хүнд ноогдох ДНБ 6311.4 мян.төгрөг, аймгийн ДНБ-ний дийлэнх буюу 51.5 хувийг үйлчилгээний салбар, 27.55 хувийг аж үйлдвэр, барилгын салбар, 20.9 хувийг ХАА-н салбар эзэлж байна. 464203 толгой малтай.



Аймгийн хэмжээнд бүртгэлтэй 698 хуулийн этгээд, аж ахуйн нэгж байгууллага байгаа бөгөөд эдгээрийг хариуцлагын хэлбэрээр авч үзвэл ХК-1, ХХК-365, ББН -5, ЗБН -9, Хоршоо -29, ХЗХоршоо- 1, ОНӨҮГ-6, салбар-66, төсөвт болон төрийн бус байгууллага, сан ОНБ – 216 байна.

Улсын бүртгэлд бүртгэлтэй 632 хуулийн этгээд, аж ахуйн нэгж байгаагаас нийгмийн даатгалд 221 аж ахуйн нэгж шимтгэл төлдөг. Бүртгэлтэй аж ахуйн нэгжүүдийг үйл ажиллагааны чиглэлээр нь ангилбал холбоо 101, нөхөрлөл 15, ОНӨААТҮГазар 5, сан 4, төсөвт байгууллага 58, төрийн өмчит хувьцаат компани 1, үйлдвэрчний эвлэлийн байгууллага 9, хоршоо 42, гадаадын хөрөнгө оруулалттай хязгаарлагдмал хариуцлагатай компани 4, хязгаарлагдмал хариуцлагатай компани 389, шашны байгууллага 4 тус тус байна.

Орон нутагт бүртгэлгүй, нийгмийн даатгалын шимтгэл төлдөг 44 аж ахуйн нэгж байгаагаас банкны салбар 6, Улаанбаатар төмөр зам ХНН-ийн харьяа 3, даатгалын байгууллагын салбар 3, газрын тосны бүтээгдэхүүн агуулах, түгээх станц 4, тээвэр логистикийн 7, боловсруулах үйлдвэр 2, бусад 19 аж ахуйн нэгж, түүний салбар байна.

Төрийн байгууллагуудад нийт 2072, орон нутгийн өмчит байгууллагуудад 241, төрийн өмчит хувьцаат компанид 594, хувийн хэвшилд 2601, нийт 5508 иргэн ажиллаж байгаа бөгөөд сул ажлын байрыг авч үзвэл хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт бүртгэлтэй 145, төрийн албанд 71 сул орон тоо байна.

Мөн газар тариалан, худалдаа, үйлдвэрлэл үйлчилгээний салбарт 364 сул орон тоо байна.

### **Хоёр. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим**

2.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтлана. Үүнд:

2.1.1. Монгол Улсын хууль, хөгжлийн бодлогын баримт бичиг, холбогдох үндэсний хөтөлбөрүүд, аймаг орон нутгийн бодит нөөц бололцоо, бүс нутгийн эдийн засгийг кластержуулан хөгжүүлэх, орон нутаг өөрийгөө бие даан санхүүжүүлэх эдийн засгийн бодлогод тулгуурлах;

2.1.2. Аймаг, орон нутагт шилжин ирж ажиллаж амьдрах, үйл ажиллагаа эрхлэн явуулахад үүсэх давуу тал болон үүсч болзошгүй хүндрэл бэрхшээлийг зөв тооцож тусгахыг эрмэлзэн мэдээллийг нээлттэй, тэгш, хүртээмжтэй түгээхийг чухалчилсан, хувь хүн, ААН, байгууллагад хуулиар олгогдсон эрхийг дээдлэн хүндэтгэсэн, үүрэг хариуцлагыг ухамсарлуулан таниулж хандлагын өөрчлөлтөд уриалсан, бизнесийн орчны тэгш боломж, шударга өрсөлдөөнийг эрхэмлэсэн,

хөгжил дэвшил, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын таатай орчин, олон талт харилцааны онцлогуудыг уялдуулан тодорхойлсны үндсэн дээр хөтөлбөрийг хэрэгжүүлэх.

2.1.3. Хөтөлбөрийг иргэд олон нийт, аж ахуйн нэгж, байгууллага, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагууд, бизнесийн болон мэргэжлийн холбоодын оролцоонд тулгуурлан хэрэгжүүлэх.

### **Гурав. Хөтөлбөрийн зорилго**

3.1. Хөтөлбөрийн зорилго нь аймагт шилжин ирж суурьшин ажиллаж амьдрах, иргэд, ААН, байгууллагыг угтан авахад шаардагдах бэлтгэлийг хангах, аймгийн хөгжлийн тэргүүлэх чиглэл, бодлогын зорилттой уялдуулан нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах замаар “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулж, аймаг, орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд дэмжлэг үзүүлэх.

### **Дөрөв. Хөтөлбөрийн зорилт**

4.1. “Нээлттэй аймаг хөтөлбөр”-ийг ажил хэрэг болгохдоо дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ. Үүнд:

4.1.1. Хүн ам, үйлдвэрлэл үйлчилгээний хүчин чадал, татварын бааз суурийг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн хувьд бие даах нөхцлийг бүрдүүлэх.

4.1.2. Бизнесийн таатай орчныг бүрдүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг хангах.

4.1.3. Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, суурь дэд бүтцийг өргөтгөж, иргэдийн ажиллаж, амьдрах орчин, нөхцлийг сайжруулах, ажлын байраар хангах, хүний хөгжлийг дэмжих замаар нийгмийн харилцааг хөгжүүлэх.

### **Тав. Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл**

5.1. Нээлттэй аймаг хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараах чиглэлийг баримтлана. Үүнд:

5.1.1. Амьдрах таатай орчин бүрдүүлэх, дэд бүтцийг өргөтгөх, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, уялдаа холбоог хангах, хөрөнгө оруулалт татах чиглэлд идэвх санаачлага гаргах;



5.1.2. Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудтай хамтын ажиллагааг идэвхжүүлж аймагтаа ажлын байр нэмэгдүүлэх;

5.1.3. Боловсрол, эрүүл мэндийг салбарын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах;

5.1.4. Үндэсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, аймгийн брэнд бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгон сурталчлах; үйлдвэрлэл, аялал жуулчлал гэх мэт бодит хөрөнгө оруулалт оруулах салбараа эрэмбэлэн хөгжүүлэх, иргэдийн тогтмол орлого олох боломжийг эрэлхийлэх;

5.1.5. Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг эрчимжүүлж, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудыг мэдээллээр хангах, тэднийг аймаг орон нутагт шилжин ирж суурьшин амьдрах сэдлийг төрүүлэх, хандлагыг өөрчлөх, амьдрах таатай орчин бүрдүүлэх, мэдээллээр хангах чиглэлд аймаг, орон нутаг манлайлан оролцож, эдгээрт чиглэсэн үйл ажиллагаа, арга хэмжээнүүдийг зохион байгуулж тогтмолжуулах;

5.1.6 Хөтөлбөрт дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагааны хэрэгжилтийн явцад тавих хяналтыг нэмэгдүүлэх;

### **Зургаа. Авч хэрэгжүүлэх арга хэмжээ**

#### **6.1. Хүн ам, үйлдвэрлэл үйлчилгээний хүчин чадал, татварын бааз сүүрийг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн хувьд бие даах нөхцөлийг бүрдүүлэх зорилтын хүрээнд:**

6.1.1. Аймаг, орон нутгийг сурталчлах, уулзалт, зөвлөгөөн, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд мэдээлэл хүргэх.

6.1.2. Орон нутагт бүртгэлтэй, үйл ажиллагаа нь зогссон аж ахуйн нэгжүүдэд үйл ажиллагааг үргэлжлүүлэх, хүчин чадлаа нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

6.1.3. Улаанбаатар хотод бүртгэлтэй боловч орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн салбарыг орон нутагт татвар төлөгчөөр бүртгэх.

6.1.4. Орон нутагт ажиллаж, амьдарч байгаа боловч шилжин ирээгүй иргэдийг шилжүүлэх, бүртгэх.

6.1.5. Баянтал суманд боловсруулах үйлдвэр, тээвэр логиستيкийн төв байгуулахыг бодлогоор дэмжих.

6.1.7. Баянтал суманд цэргийн анги байгуулахыг бодлогоор дэмжих.



6.1.8. Сүмбэр суманд Чойр өртөөг өргөтгөж, авто болон төмөр замд тулгуурласан тээвэр логистикийн төв байгуулах ажлыг судалж, бодлогоор дэмжих

6.1.9. Автозамыг түшиглэн авто үйлчилгээний төв, гүний гааль байгуулах, транзит тээврийн үйл ажиллагааг дэмжих.

6.1.10. Сүмбэр суманд дутагдалтай худалдаа, үйлчилгээний төвүүдийг байгуулах, худалдаа, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг томоохон татвар төлөгч аж ахуйн нэгжүүдийн салбаруудыг байгуулахыг бодлогоор дэмжих.

6.1.12. Орон нутаг болон бүс нутгийг хүнсээр хангах, хүнсний зориулалтаар стандартад нийцсэн агуулах зоорийг нэмэгдүүлэх, хүнсний үйлдвэрлэлийг кластераар хөгжүүлэх.

6.1.13. Уул уурхайн жишиг сургууль Политехникийн коллежийг дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэдэг шаталсан сургалттай болгож, шаардлагатай инженер техникийн ажилчдыг бэлтгэх боломжийг бүрдүүлэх.

6.1.14. Шивээговь суманд нүүрс, химийн болон эрчим хүчний үйлдвэрлэлийг бий болгоход бодлогоор дэмжих.

6.1.16. Орон нутагт уул уурхайн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, олборлолт, тээвэрлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдтэй нийгмийн хариуцлагын гэрээ байгуулан хамтран ажиллах.

6.1.17. Орон нутагт шаардлагатай мэргэжлээр суралцах, мөн шилжин ирж ажиллах нарийн мэргэжлийн хүний нөөц, инженер, техникийн ажилтан, мэргэжилтнүүдийн ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлж, санхүүгийн болон орон байрны дэмжлэгийг үзүүлэх.

## **6.2. Бизнесийн таатай орчныг бүрдүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг хангах зорилтын хүрээнд:**

6.2.1. Татварын шаталсан тогтолцоог хэрэгжүүлж, бизнес эрхлэгчид, аж ахуйн нэгж, байгууллагыг татварын бодлогоор дэмжих.

6.2.2. Чойр хотын болон Шивээговь, Баянтал сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэх, суурьшлын бүсийг өргөтгөх, хот төлөвлөлт, газар зохион байгуулалтыг сайжруулах.

6.2.3. Дэд бүтцийг өргөтгөх, инженерийн байгууламжуудын хүчин чадлыг нэмэгдүүлэх замаар бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх.

6.2.4. Бизнес эрхлэгчид болон гарааны бизнесийг зээлийн болон газрын бодлогоор дэмжих



**6.3. Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, сүүр дэд бүтцийг өргөтгөж, иргэдийн ажиллаж, амьдрах орчин, нөхцөлийг сайжруулах, ажлын байраар хангах, хүний хөгжлийг дэмжих замаар нийгмийн харилцааг хөгжүүлэх зорилтын хүрээнд:**

6.3.1. Шилжин ирж байгаа иргэдийг орон сууцаар хангах зорилгоор хуучин 555 айлын орон сууцыг үе шаттай засварлах, шинээр 428 айлын орон сууц барих ажлыг төр болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар үе шаттайгаар шийдвэрлэх.

6.3.2. Аймгийн хэмжээнд газар тариалангийн бүс нутгийг бий болгож газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих

6.3.7. Мал аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, эрчимжсэн аж ахуйг дэмжих.

6.3.3. Сумдын ундны усны эх үүсвэрийн судалгааг хийж, нөөцийг нэмэгдүүлэх.

6.3.4. Нийтийн эзэмшлийн талбайн тохижилтыг сайжруулан, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх.

6.3.5. Хүн амын өсөлттэй уялдуулан сургууль, цэцэрлэгийг өргөтгөж, хүчин чадлыг нэмэгдүүлж, сургалтын чанар, хүртээмжийг дээшлүүлэх.

6.3.6. Хүн амын өсөлттэй уялдуулан эрүүл мэндийн байгууллагуудын хүчин чадал, хүний нөөцийн хангамжийг нэмэгдүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх.

6.3.8. Иргэдийн ажиллаж амьдрах орчин нөхцөлийг сайжруулах.

**Долоо. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт**

7.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн хэмжээнд удирдан зохион байгуулах үүрэг бүхий дэд ажлын хэсэг (цаашид “ажлын хэсэг” гэх) удирдан зохион байгуулж ажиллана.

7.2. Ажлын хэсэг аймгийн хэмжээнд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж аймгийн Засаг даргаар батлуулна.

7.3. Аймгаас мэдээллээ нээлттэй түгээх зорилгоор Улаанбаатар хот болон бүс нутгийн түвшинд зохион байгуулагдах үзэсгэлэн худалдаа, форум, хурал зөвлөгөөн, спорт, соёл урлагийн арга хэмжээнд оролцож аймгаа сурталчлах ажлыг зохион байгуулж ажиллана.

7.4. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад ажлын хэсгээс тогтмол хяналт тавьж, хагас болон бүтэн жилээр хэрэгжилтийг дүгнэн хэлэлцэж, аймгийн Засаг дарга,



аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнана.

### **Найм. Хэрэгжүүлэх хугацаа**

8.1. Хөтөлбөрийн эхний шатыг 2023-2024 оны 1 дүгээр улирал дуустал нийт 15 сарын хугацаанд хэрэгжүүлнэ.

### **Ес. Хөтөлбөр хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр**

9.1. Хөтөлбөрийг дараах санхүүгийн эх үүсвэрээр хэрэгжүүлнэ. Үүнд:

9.1.1. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө;

9.1.2. Хөгжлийн хөтөлбөрүүд, олон улсын байгууллагын тусламжийн хөрөнгө;

9.1.3. Хувийн хэвшлийн хандив, тусламжийн хөрөнгө;

9.1.4. Бусад.

9.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу тухайн жилийн үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг жил бүрийн орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлнэ.

### **Арав. Хөтөлбөрийн хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт**

10.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараах шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ.

10.1.1. Аймагт шилжин ирсэн иргэдийн бодит тоон өсөлт 10%-иас доошгүй нэмэгдсэн эсэх;

10.1.2. Үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ, бүтээн байгуулалт, аялал жуучлал гэх мэт бүх төрлийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжийн тоо;

10.1.3. Аймаг орон нутагт шинээр бий болсон ажлын байрны тоо, нөхөгдсөн сул орон тоо, хувь

10.1.4. Орон нутагт иргэдийг татах чиглэлээр олон нийтэд чиглэж зохион байгуулсан ажлын тоо, иргэдийн оролцооны хувь;

10.1.5. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 тоот тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын “Хүн амын нэмэгдэлтийн хувь, төсвийн байгууллага, хуулийн этгээд тэдгээрийн салбар нэгжийн болон албан хаагчийн шилжилтийн хувь” шалгуур үзүүлэлтээр хэрхэн дүгнэгдсэн байдал;

10.2. Ажлын хэсэг хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт бүрээр хүрэх зорилтот үзүүлэлтийг жил бүр тогтооно.



**Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин**

№	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин
		2022 он	2024 он (1 дүгээр улирал)
1	Хүн амын тоо	18042	20000
2	Дотоодын нийт бүтээгдэхүүн, сая.төг	155,31569	170,300.0
3	Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх аж үйлдвэрийн бүтээгдэхүүний хувь	27.5	29.2
4	Татвар төлөгч аж ахуйн нэгжийн тоо	698	718
5	Төсвийн орлого, мян.төг	9,541,660	10,175,001
6	Улсаас авах татаас, мян.төг	2,112,150.5	1,478,500
7	Шилжиж ирсэн иргэдийн, тоо	-	1500
8	Шинээр бий болсон байнгын ажлын байр, тоо	123	350
9	Шинээр бий болсон түр ажлын байр, тоо	261	783